



МОНГОЛ УЛСЫН
ЭРҮҮЛ МЭНДИЙН САЙДЫН
ТУШААЛ

2017 оны 11 сарын 07 өдөр

Дугаар А/412

Улаанбаатар хот

Хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний
төлөвлөгөө батлах тухай

Хөгжлийн бодлого төлөвлөлтийн тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.6 дахь хэсэг, “Хөтөлбөр батлах тухай” Засгийн газрын 2017 оны 225 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. “Орчны эрүүл мэнд” үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг хавсралт ёсоор баталсугай.

2. Төлөвлөгөөнд заасан арга хэмжээний хэрэгжилтийг салбар дундын уялдаатайгаар зохион байгуулж, гүйцэтгэлд хяналт тавьж, үр дүнг тогтоосон хугацаанд тайлагнаж ажиллахыг Засгийн газрын гишүүд, аймаг, нийслэлийн Засаг дарга нарт зөвлөсүгэй.

3. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Эрүүл мэндийн яамны Төрийн нарийн бичгийн дарга /Д.Очирбат/-д үүрэг болгосугай.

САЙД



Д.САРАНГЭРЭЛ

081343

2017 оны 11 сарын 14-ны өдрийн
 дугаар тушаалын хавсралт



ОРЧНЫ ЭРҮҮЛ МЭНД ҮНДЭСНИЙ ХӨТӨЛБӨРИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ

Зорилго		Хүрээлэн байгаа орчны бохирдол, уур амьсгалын өөрчлөлтөөс хүний эрүүл мэндэд үзүүлж байгаа нөлөөллийг бууруулах замаар хүний эрүүл, аюулгүй орчинд амьдрах, ажиллах, суралцах нөхцөлийг сайжруулах				
Үр нөлөө (үр нөлөөний шалгуур үзүүлэлт)		Хөтөлбөрийг хэрэгжүүлснээр хүн амын суурьшлын орчны агаар, ундны усны чанар, аюулгүй байдлын үзүүлэлт сайжирч, хөрсний бохирдолтын түвшин буурч, орчны бохирдлоос үүдэлтэй хүн амын өвчлөл, нас баралт буурна.				
№	Үйл ажиллагаа	Бүтээгдэхүүн	Шалгуур үзүүлэлт	Хэрэгжилтийг хариуцах байгууллага	Хамтран хэрэгжүүлэх байгууллага	Хэрэгжих хугацаа
Зорилт 1. Агаарын чанарыг сайжруулж, агаарын бохирдлоос хүний эрүүл мэндэд үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах						
Үйл ажиллагааны чиглэл 1. Агаарын чанарыг сайжруулах эрх зүйн орчинг боловсронгуй болгох						
1.1.1	Хүний эрүүл мэндэд сөрөг нөлөө үзүүлж буй агаарын бохирдлын төлбөрийн орлогын тодорхой хувийг нийгмийн эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх үйл ажиллагаанд зарцуулах эрх зүйн орчин бүрдүүлэх	Засгийн газрын тогтоол	Агаарын бохирдлын төлбөрийн орлогын тодорхой хувийг нийгмийн эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх үйл ажиллагаанд зарцуулах эрх зүйн орчин бүрдсэн байна.	БОАЖЯ, СЯ, ЭМЯ	НЭМҮТ	2017-2018
1.1.2	Агаарын чанарын индексийг шинэчлэн боловсруулах	БОАЖ-ын сайдын тушаал	Агаарын чанар. Техникийн ерөнхий шаардлага MNS 4586:2016 нийцүүлэн агаарын чанарын индексийг	БОАЖЯ, ЭМЯ	НАЦА, НЭМҮТ	2017-2018

			Боловсруулж, хэрэгжилтэд хяналт тавьж мөрдүүлсэн байна.		
Үйл ажиллагааны чиглэл 2. Агаарын бохирдлоос хүний эрүүл мэндэд үзүүлэх нөлөөллийг тандан судлах					
2.2.1	Улирлын чанартай амьсгалын замын цочмог халдварт өвчин дэгдэх үед эрүүл мэндийн байгууллагын бэлэн байдлыг хангах, хариу арга хэмжээг шуурхай зохион байгуулах	ЭМС-ын тушаал	Бэлэн байдлыг хангах, хариу арга хэмжээг шуурхай зохион байгуулах нөхцлийг бүх шатны эрүүл мэндийн байгууллагад бүрдүүлсэн байна.	ЭМЯ Эрүүл мэндийн байгууллагууд	2017-2020
2.2.2	Агаарын бохирдол ихтэй бүс нутагт агаарын бохирдлоос үүдэлтэй өвчин эмгэг, тухайлбал, харшил, уушгины багтраа, уушгины хорт хавдар, жирэмсний хүндрэл зэрэгт нарийвчилсан судалгаа хийх, судалгааны дүнг үндэслэн хэрэгжүүлэх арга хэмжээг төлөвлөх, хэрэгжилтийг хангах	Судалгааны ажлын тайлан, зөвлөмж Судалгааны дүнд үндэслэн хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө	Судалгаа хийгдэж, үр дүнг олон нийтэд мэдээлсэн байна. Төлөвлөгөө боловсруулж хэрэгжсэн байна.	НЭМҮТ, АШУИС-ийн НЭМС, АӨСҮТ, ЭХЭМҮТ, МАУА ЭМЯ	2018-2020
2.2.3	Агаарын бохирдлоос хүний эрүүл мэндэд болон эрүүл мэндийн салбарт учруулж байгаа санхүүгийн дарамт, эдийн засгийн хохирлын тооцоог үндэсний түвшинд хийх	Судалгааны ажлын тайлан	Холбогдох байгууллагуудыг мэдээллээр хангасан байна.	НЭМҮТ, АШУИС-ийн НЭМС НЭМГ, ЭМХТ	2018-2020
2.2.4	Ажлын онцлогоос хамаарч гадаа байнга ажилладаг замын цагдаа, хот тохижилтын үйлчилгээний ажилтан, шатахуун түгээх станцын түгээгч зэрэг ажилтны дунд агаарын бохирдлын өртөлтийн үнэлгээ хийх, эрсдэлээс урьдчилан сэргийлэх арга	Үнэлгээний тайлан	Улаанбаатар хотын Замын цагдаагийн албаны зохицуулагч цагдаа, Хот тохижилтын үйлчилгээний ажилчид, Шатахуун түгээх станцийн түгээгч нарт агаарын бохирдлын өртөлтийн үнэлгээ хийгдсэн байна.	АШУИС-ийн НЭМС НЭДТГ, ЗЦА, УУХУЯ	2018-2020

	хэмжээг зохион байгуулах				
	Улаанбаатар хотод үйл ажиллагаа явуулж байгаа хэсгийн халаалттай өрхийн эрүүл мэндийн төвийн халаалтыг шинэчлэх асуудлыг үе шаттайгаар шийдвэрлэх	Үнэлгээний тайлан	Хэсгийн халаалттай өрхийн эрүүл мэндийн төвүүд халаалтын шинэ горимд шилжсэн байна.	НЭМГ, НЗДТГ	ЭМЯ, ЭХЯ 2018-2020
2.2.5	Агаарын чанарыг сайжруулах бүсэд мөрдөх дэглэмийн хэрэгжилтэд хяналт тавьж, гарсан дүгнэлт, зөвлөмжийг олон нийтэд ил тод мэдээлэх	Хяналт, үнэлгээний тайлан	Дэглэмийн хэрэгжилтэд хяналт тавьж, гарсан дүгнэлт, зөвлөмжийг олон нийтэд ил тод мэдээлсэн байна.	МХЕГ, НМХГ	НЗДТГ, НЭМҮТ 2017-2020
2.2.6	Агаарын чанарт эрсдэлд суурилсан хяналт, үнэлгээг үндэсний түвшинд тогтмол хийж, холбогдох ара хэмжээг шуурхай зохион байгуулах	Хяналт, үнэлгээний тайлан	Эрсдэлд суурилсан хяналт, үнэлгээ хийгдэж, зөвлөмжийг холбогдох байгууллагад хүргүүлсэн байна.	МХЕГ, НМХГ	НЭМҮТ 2017-2020
Үйл ажиллагааны чиглэл 3. Агаарын бохирдлоос үүдэлтэй өвчлөлөөс урьдчилан сэргийлэх үйл ажиллагааг эрчимжүүлэх					
3.3.1	Агаарын бохирдол ихтэй бүс нутгийн нэг хүртэлх насны хүүхдийг пневмококийн эсрэг дархлаажуулалтад хамруулах	Эрүүл мэндийн сайдын тушаал	Агаарын бохирдол ихтэй бүс нутгийн нэг хүртэлх насны хүүхдийн 90 хүртэлх хувийг пневмококийн эсрэг дархлаажуулалтад хамруулсан байна.	ХӨСҮТ, АНЭМГ	ЭМЯ 2017-2020
3.3.2	Агаарын бохирдол ихтэй бүс нутгийн эрсдэлт бүлгийн хүн амыг томуугийн эсрэг дархлаажуулалтад хамруулах	Эрүүл мэндийн сайдын тушаал	Агаарын бохирдол ихтэй бүс нутгийн эрсдэлт бүлгийн хүн амыг томуугийн эсрэг дархлаажуулалтын хамралт 40 хувиар нэмэгдсэн байна.	ХӨСҮТ, АНЭМГ	ЭМЯ 2017-2020
3.3.3	Гэр, орон байрны доторх агаарыг бохирдуулах эх үүсвэр, түүнээс хүний эрүүл мэндэд нөлөөлөх эрсдэлийг	Судалгааны тайлан, иргэдэд зориулсан зөвлөмж	Гэр, орон байрны доторх агаарыг бохирдуулах эх үүсвэр, түүний эрүүл мэндэд үзүүлэх эрсдэл, зөвлөмжийг олон	АШУИС-ийн НЭМС, НЭМҮТ	БСШУСЯ, БХБЯ, ТББ 2017-2020

	тодорхойлж, нөлөөллийг бууруулах урьдчилан сэргийлэх арга хэмжээг зохион байгуулах	Олон нийтийн хэвлэл, мэдээллийн хэрэгслээр хүн амд мэдээлэл түгээсэн тайлан	нийтийн хэвлэл мэдээллийн хэрэгслээр түгээсэн байна.			
3.3.4	Дотоод орчны агаар дахь дэгдэмхий бохирдуулагчдын эрүүл мэндэд үзүүлэх нөлөөллийг судлах	Судалгааны тайлан, иргэдэд зориулсан зөвлөмж	Дотоод орчны агаар дахь дэгдэмхий бохирдуулагчдын эрүүл мэндэд үзүүлэх нөлөөллийг тогтоосон байна.	АШУИС-ийн НЭМС	НЭМҮТ	2018-2020
Үйл ажиллагааны чиглэл 4. Агаарын бохирдлоос хүний эрүүл мэндэд үзүүлэх сөрөг нөлөөллийн талаар хүн амын дунд мэдээлэл, сурталт, сурталчилгаа хийх, олон нийтийн санаачилгыг дэмжих						
	Агаарын бохирдлоос хүн амын эрүүл мэндэд үзүүлэх сөрөг нөлөөлөл, түүнээс урьдчилан сэргийлэх талаар хийх сурталт, сурталчилгааг өргөжүүлэх, агаарын бохирдлыг бууруулахад иргэд, олон нийт, төрийн бус байгууллагын санал, санаачлагыг дэмжих	Мэдээлэл сурталт, сурталчилгааны аяны төлөвлөгөө	Хүн амд олон нийтийн хэвлэл, мэдээллийн хэрэгсэл, нийгмийн сүлжээгээр сурталчилсан байна.	ЭМЯ, АНЗДТГ	БОАЖЯ, НЭМҮТ, АНЭМГ	2017-2020
3.4.1		Боловсруулсан сурталт сурталчилгааны материал	Хүн амд зориулсан санамж, гарын авлага боловсруулж нийтийн хүртээл болгосон байна.	АНЗДТГ, ШУА	БОАЖЯ, НЭМҮТ, АНЭМГ, БСШУСЯ	2017-2020
		Сурталт, сурталчилгаа, компанит ажил, аян	Сурталт, сурталчилгаа, компанит аяныг тогтмолжуулж, иргэд олон нийт, ТББ-ын санаачлагыг дэмжиж ажилласан байна.	АНЗДТГ, Агаарын бохирдлын эсрэг сан	НЭМҮТ, АНЭМГ, Хувийн хэвшил	2017-2020
3.4.2	Гэр хорооллын бүсэд байрлуулах "Агаарын чанарын ухаалгаг хяналтын систем"-ийн тоог нэмэгдүүлэх	Шинээр 3-5 агаарын чанарын ухаалгаг системийг байршуулах	Агаарын чанарын бүсийн дэглэмийн хэрэгжилтэнд хяналт хийж, олон нийтэд мэдээлэл хүргэсэн байна.	НЗДТГ	НАЧА, НЭМҮТ	2017-2020
3.4.3	Дам тамхидалтын хор уршгийн талаар иргэдэд зориулсан	Дам тамхидалтын	Дам тамхидалтын талаарх олон нийтийн зориулсан мэдээлэл	ЭМЯ	Харьяа байгууллагуу	2017-2020

	зөвлөмж, сурталчилгааны боловсруулан түгээх материал	хор уршгийн талаар иргэдэд зориулсан зөвлөмж, суртал сурталчилгааны материал	сурталт материалын тоо, төрөл, мэдээлэл авсан хүний тоо жил бүр нэмэгдсэн байна.	д	
3.4.4	Нялх, бага насны хүүхдийг эхийн сүүтээр дагнан хооллох, 2 нас хүртэл үргэлжлүүлэн хооллохыг сурталчлах ажлыг зохион байгуулах	Мэдээлэл, сурталт, сурталчилгааны стратеги Сурталчилгааны материал	Нялх, бага насны хүүхдийг эхийн сүүтээр дагнан хооллох, 2 нас хүртэл үргэлжлүүлэн хооллохыг сурталчилсан материалын тоо, төрөл, мэдээлэл авсан хүний тоо жил бүр нэмэгдсэн байна.	ЭМЯ Харьяа байгууллагууд	2017-2020

Зорилт 2. Ундны усны чанар, аюулгүй байдлыг хангаж, хөрсний бохирдлоос хүний эрүүл мэндэд үзүүлэх нөлөөллийг бууруулах

Үйл ажиллагааны чиглэл 1. Ундны усны чанар, аюулгүй байдал, ариун цэврийн байгууламжийг сайжруулах эрх зүйн орчинг боловсронгуй болгох

2.1.1	Ундны усны ундэсний стандартыг шинэчлэн боловсруулж батлуулах	Батлагдсан стандарт	Стандарт мөрдүүлсэн байна.	ЭМЯ, БОАЖЯ	МХЕГ, НЭМҮТ, УСҮГ, СХЗГ	2017-2018
2.1.2	Ус хангамж, ариун цэврийн байгууламжийн сүлжээнд эрсдэлийн үнэлгээ хийх заавар боловсруулах, ундэсний хэмжээнд үнэлгээ хийх, үнэлгээ хийх ажлыг мэргэжил, арга зүйн удирдлагаар хангах	ЭМ, БХБ-ын сайдын хамтарсан тушаал	Тушаал батлагдаж мөрдөгдсөн байна.	ЭМЯ, БХБЯ	УСҮГ	2017-2020
2.1.3	Жижиг суурин газарт ундны усны аюулгүй байдлын төлөвлөгөө боловсруулах аргачилсан заавар батлуулах, боловсруулах, зааврын	Аргачилсан заавар	Заавар батлагдаж мөрдөгдсөн байна.	ЭМЯ	УСҮГ	2017-2020

	хэрэгжилтэд хяналт тавих					
2.1.4	Хүн амын суурьшлын бүсийн хөрсний эрүүл ахуйн стандартыг боловсруулж, батлуулан хэрэгжүүлэх	Стандарт	Стандарт батлагдаж, мөрдүүлсэн байна.	ЭМЯ, БОАЖЯ, НМХГ	СХЗГ	2017-2018
2.1.5	Сургалт хүмүүжлийн байгууллагын ус, ариун цэвэр, эрүүл ахуйн нөхцөлийг сайжруулах	Ерөнхий боловсролын сургууль, дотуур байр, сургалт, хүмүүжлийн байгууллагын орчны эрүүл ахуйн стандарт	Стандарт батлагдаж, мөрдүүлсэн байна.	ЭМЯ, БСШУСЯ	НМХГ, СХЗГ, ТТБ	2017-2019
		Үнэлгээний тайлан	Хэрэгжилтэд үнэлгээ хийсэн байна	МХЕГ, НМХГ	НЗДТГ, ТББ	2019-2020
Үйл ажиллагааны чиглэл 2. Үндны усны аюулгүй байдлын төлөвлөгөө боловсруулан хэрэгжүүлэх						
2.2.1	Ус хангагч байгууллагад усны аюулгүй байдлын төлөвлөгөө боловсруулах, хэрэгжүүлэхэд арга зүйн дэмжлэг үзүүлэх	Үндны усны аюулгүй байдлын төлөвлөгөө Аудит	Үндны усны аюулгүй байдлын төлөвлөгөөг 21 аймгийн ус хангагч байгууллага батлуулан хэрэгжүүлсэн байна. УБ болон 10 аймгийн ус хангагч байгууллагад хэрэгжиж буй усны аюулгүй байдлын төлөвлөгөөнд хөндлөнгийн аудит хийгдсэн байна.	НЭМҮТ, АШҮҮИС-ийн НЭМС, УСҮГ, МХЕГ, НМХГ	ЭМЯ, БХБЯ	2017-2020
2.2.2	Жижиг суурин газарт усны аюулгүй байдлын төлөвлөгөөг тухайн орон нутгийн онцлог, хүн амын тоо, ус хангамжийг харгалзан зааврын дагуу боловсруулж хэрэгжүүлэх	ЭМБ, сургууль, цэцэрлэг, дүүрэг, хорооны үндны усны аюулгүй байдлын төлөвлөгөө	24 жижиг суурин газарт усны аюулгүй байдлын төлөвлөгөөг шинээр боловсруулсан байна.	НЭМҮТ, МХЕГ, НМХГ, АШҮҮИС-ийн НЭМС, УСҮГ	ЭМЯ, МУЗН, НЗДТГ	2017-2020

2.2.3	Ундны усны аюулгүй байдлыг хангах төлөвлөгөөний хэрэгжилтэд олон улсын аргачлалаар үнэлгээ хийх чадвар бүхий аудиторыг бэлтгэх	Сургалт	Үндэсний хэмжээнд 10 хүртэлх аудитор бэлтгэгдсэн байна.	УСУГ, АШУИС-ийн НЭМС	ЭМЯ, СХЗГ	2017-2020
2.2.4	Эрүүл мэнд, байгаль орчны асуудал эрхэлсэн сайд нарын хамтарсан тушаалаар байгуулсан "Ус, ариун цэврийн байгууламжийн ажлын хэсэг"-ийн уулзалтыг улирал бүр зохион байгуулах, салбар дундын хамтын ажиллагааг сайжруулах	Ажлын хэсгийн уулзалтын хөтөлбөр, шийдвэр	Жилд 4 удаа хуралдаж салбар дундын хамтын ажиллагаа сайжирна.	ЭМЯ, БОАЖЯ	НЭМУТ, ажлын хэсэг	2017-2020

Үйл ажиллагааны чиглэл 3. Хүн амын ундны усны стандарт, ундны усны эх үүсвэрийн бүсийн дэглэм болон эрүүл мэнд, боловсролын байгууллагын ариун цэвэр, эрүүл ахуйн нөхцөлд үнэлгээ хийх

2.3.1	Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ үзүүлэх байгууллагад ундны ус, ариун цэвэр, эрүүл ахуйн нөхцөлийг үнэлэх хяналтын хуудас нэвтрүүлэх, үнэлгээ хийх	Үнэлгээний тайлан	Үнэлгээ хийгдэж, цаашид авах арга хэмжээний саналыг тодорхойлж, холбогдох байгууллагад хүргүүлсэн байна.	МХЕГ, АНМХГ	ЭМЯ	2017-2018
2.3.2	Эрүүл мэндийн байгууллагын эрүүл ахуйн үнэлгээ хийх	Үнэлгээний тайлан	Цаашид авах арга хэмжээний саналыг эрүүл мэндийн тусламж үйлчилгээ үзүүлдэг бүх байгууллагуудад хүргүүлсэн байна.	НЭМУТ	ЭМЯ, АНЭМГ	2017-2018
2.3.3	Үндэсний түвшинд ДЭМБ-ын аргачлалын дагуу хүн амын ундны ус, ариун цэврийн байгууламжийн үнэлгээг 2 жил тутамд хийх	Үнэлгээний тайлан	Үнэлгээний тайланг ДЭМБ-д хүргүүлсэн байна.	ЭМЯ, БОАЖЯ, БХБЯ, БСШУСЯ	НЭМУТ, МХЕГ	2017, 2019
2.3.4	Цэцэрлэг, ерөнхий	Үнэлгээний	Усан хангамж, ариун цэвэр,	НМХГ,	ЭМЯ,	2017-

	боловсролын сургууль, дотуур байрны усан хангамж, ариун цэвэр, эрүүл ахуйн нөхцөлд үнэлгээ хийж, сайжруулах арга хэмжээг үе шаттайгаар хэрэгжүүлэх	тайлан	эрүүл ахуйн нөхцлийн үнэлгээнээс гарсан сайжруулах арга хэмжээний зөвлөмжийг холбогдох байгууллагуудад хүргүүлсэн байна.	АШУУИС-ийн НЭМС	БСШУСЯ, ТББ	2020
2.3.5	"Нийгмийн үзүүлэлтийн туувэр судалгаа"-ны арга, аргачлалд эрүүл ахуйн шаардлага хангасан үндны ус, ариун цэврийн байгууламжаар хангагдсан хүн амын эзлэх хувийг тооцох аргачлал, асуумжийг шинээр нэмж оруулах, тооцох	Батлагдсан судалгааны арга, аргачлал Судалгааны тайлан	Нийгмийн үзүүлэлтийн туувэр судалгаагаар эрүүл ахуйн шаардлага хангасан үндны ус, ариун цэврийн байгууламжаар хангагдсан хүн амын эзлэх хувь тодорхойлогдсон байна.	УСХ, БХБЯ, ЭМЯ	НЭМҮТ	2018
2.3.6	Хот, суурин газрын хүн амын үндны усны чанар, аюулгүй байдалд эрсдэлд суурилсан хяналт, үнэлгээ хийх	Эрсдэлд суурилсан хяналт, үнэлгээний тайлан	Эрсдэлд суурилсан хяналт хийж, зөвлөмжийг холбогдох байгууллагуудад хүргүүлсэн байна.	МХЕГ, НМХГ	Бүх шатны Засаг дарга	2017- 2020
2.3.7	Хөдөөгийн хүн амын үндны усны чанар, аюулгүй байдалд эрсдэлд суурилсан хяналт, үнэлгээг хийх	Хяналт, үнэлгээний тайлан	Эрсдэлд суурилсан үнэлгээний зөвлөмжийг холбогдох байгууллагуудад хүргүүлсэн байна.	МХЕГ	ЭМЯ	2017- 2019
2.3.8	Үндны усны эх үүсвэрийн эрүүл ахуйн болон энгийн хамгаалалтын бүсийн дэглэмийн хэрэгжилтэд эрсдэлд суурилсан хяналт, үнэлгээ хийх	Хамгаалагдсан үндны усны эх үүсвэрт хяналт, үнэлгээ	Хамгаалалтын бүсийн дэглэмд хяналт, үнэлгээний зөвлөмжийг холбогдох байгууллагуудад хүргүүлж, мөрдүүлнэ.	БХБЯ, БОАЖЯ	МХЕГ Бүх шатны Засаг дарга	2017- 2020
2.3.9	Ахуйн бохир ус цэвэрлэх байгууламжийн цэвэрлэгээний түвшинд хяналт, үнэлгээ хийх	Хяналт, үнэлгээ	Эрсдэлд суурилсан хяналт, үнэлгээ, судалгааны зөвлөмжийг холбогдох байгууллагуудад хүргүүлсэн байна.	МХЕГ, НМХГ	АНЗДТГ	2017- 2020

2.3.10	Хот, суурин газрын суурьшлын бус орчмын хөрсний бохирдлын байдалд үнэлгээ хийж, цаашид авах арга хэмжээг тодорхойлох	Хяналт, үнэлгээний тайлан	Зөвлөмжийг холбогдох байгууллагуудад хүргүүлсэн байна.	МХЕГ, НМХГ	Бүх шатны Засаг дарга	2017-2020
2.3.11	Хөрсний бохирдлоос гүний усанд үзүүлэх нөлөөллийг нарийвчлан судлах	Үнэлгээний тайлан	Үнэлгээ хийгдэж, цаашид авах арга хэмжээний санал дэвшүүлсэн байна.	НЭМҮТ, ШУА	МХЕГ, АШУИС-ийн НЭМС	2018-2020
Үйл ажиллагааны чиглэл 4. Хүн амд үндэсний усны чанар болон сайжруулсан ариун цэврийн байгууламжийн талаар мэдээлэл, сурталчилгаа хийх, олон нийтийн санаачилгыг дэмжих						
2.4.1	Хүн амд үндэсний усны чанар, аюулгүй байдал болон сайжруулсан ариун цэврийн байгууламжийн талаар мэдлэг, ойлголт бий болгох, эрүүл амьдрах хэв маягийг төлөвшүүлэх чиглэлээр сурталчилгаа өргөжүүлэх, энэ асуудлаар иргэд олон нийт, төрийн бус байгууллагын санал, санаачилгыг дэмжих	Мэдээлэл сурталт, сурталчилгааны аяны төлөвлөгөө	Хүн амд олон нийтийн хэвлэл мэдээлэл, нийгмийн сүлжээгээр сурталчилсан байна.	АНЗДТГ	НЭМҮТ, АНЭМГ	2017-2020
		Боловсруулсан сурталт сурталчилгааны материал	Хүн амд зориулсан санамж, гарын авлага, инфографик боловсруулж нийтийн хүртээл болгосон байна.	АНЗДТГ, МХЕГ	НЭМҮТ, АНЭМГ	2017-2020
		Сурталт, сурталчилгаа, компани ажил, аян	Сурталт, компани ажил, аяныг тогтмолжуулж, иргэд олон нийт, ТББ-ын санаачлагыг дэмжиж ажилласан байна.	АНЗДТГ, ТББ	НЭМҮТ, АНЭМГ	2017-2020
2.4.2	Нийтийн бие засах газрын тоог нэмэгдүүлэх талаар холбогдох байгууллагатай хамтран ажиллах	Зориулалтын бус газарт бие засахгүй байх сурталчилгаа	Налайх, Баянзүрх дүүрэгт иргэдийн оролцоотой ариун цэврийн байгууламжийг сайжруулах хөдөлгөөн өрнүүлж, зориулалтын бус газарт бие засахыг сурталчилсан байна.	МУЗН, Орон нутгийн төрийн захиргааны байгууллага	ЭМЯ, НЭМҮТ	2017-2020
		Судалгааны тайлан	Нийтийн бие засах газрын өнөөгийн байдал, шаардлагыг судалж, зөвлөмжийг холбогдох байгууллагад хүргүүлсэн байна.	НЭМҮТ, МХЕГ, НМХГ	ЭМЯ	2018-2019
2.4.3	Нүхэн жорлон, угадасны нүх MNS 5924:2014 стандартыг	Зөвлөмж, товхимол	Ариун цэврийн байгууламжийг сайжруулах, хөрсний бохирдлоос	НЭМҮТ, МХЕГ, НМХГ	ТББ	2017-2020

	сурталчилах, мөрдүүлэхэд төрийн бус байгууллага, иргэдийн оролцоог нэмэгдүүлэх		сэргийлэх талаар зөвлөмж, товхимол, гарын авлага, инфографик боловсруулж олон нийтийн хүртээл болгосон байна.		
2.4.4	“Хүйтэн уур амьсгалтай орнуудын ариун цэврийн байгууламжийн шийдэл” олон улсын зөвлөлдөх уулзалт зохион байгуулах	Зөвлөлтөөнөөс гарсан уриалга, зөвлөмж	Зөвлөлтөөнөөс гарсан уриалга, зөвлөмжийг холбогдох байгууллагуудад хүргүүлсэн байна.	ЭМЯ	НЭМҮТ 2017
Зорилт 3. Орчны эрүүл мэндийн тандалт, судалгааны чанарыг сайжруулах					
Үйл ажиллагааны чиглэл 1. Орчны эрүүл мэндийн тандалт, судалгаа хийх тогтолцоог боловсронгуй болгох					
3.1.1	Эрүүл ахуйн тухай хуулийг дагаж гарах дүрэм, журам, заавар боловсруулах	Батлагдсан дүрэм, журам, заавар, аргачлал	Эрх зүйн орчин шинэчлэгдэж хэрэгжиж эхэлсэн байна.	ЭМЯ, БХБЯ, БОАЖЯ, БСШҮСЯ	НЭМҮТ, НЭМХГ 2017-2020
3.1.2	Орчны эрүүл мэндийн тандалтын бүрдүүлэх ажлыг эхлүүлэх, нөөц бэхжүүлэх	Засгийн газрын тогтоол	Орчны эрүүл мэндийн тандалт, судалгаа хийх мэдээлэл цуглуулах, нэгтгэх, мэдээлэл солилцох салбар дундын эрх зүйн орчин бүрдсэн байна.	ЭМЯ, БОАЖЯ	МХЕГ, НЭМҮТ, ЭМХТ, ЦУОШГ 2017-
		Сургалтын хөтөлбөр Сургалтын авлага Сургалтанд оролцогчдын тоо	Орчны эрүүл мэндийн тандалтын мэдээгээр сар, улирал, жилээр товхимол гарсан байна.	НЭМҮТ	МХЕГ, ЭМХТ, ЦУОШГ 2017-2020
3.1.3	Орчны эрүүл мэндийн тандалт,	Мэдээллийн сан	Тандалт, судалгааны	НЭМҮТ	ЭМЯ, МХЕГ, 2018-

	судалгааны мэдээллийн сан байгуулах, цахим хуудас ажиллуулах	цахим программ	мэдээллийн сан бүрдэж, цахим программаар мэдээллийг тогтмол авч шийдвэр гаргагч, холбогдох байгууллагуудад хургуулсан байна.		ЭМХТ, ЦУОШГ	2020
3.1.4	Хот, суурин газрын дуу, шуугиан, цахилгаан соронзон орон, цацраг идэвхт бодисын түвшинд тандалт, судалгаа хийж, хүн амын эрүүл мэндэд үзүүлж байгаа нөлөөллийг үнэлэх	Судалгаа үнэлгээний тайлан	Үнэлгээний тайланг холбогдох байгууллагад хургуулсан байна.	НЭМҮТ, Цөмийн энергийн газар	МХЕГ,	2018-2019
3.1.5	Орон сууц, албан байгууллагын ажлын байрны эрүүл ахуйн нөхцөлд үнэлгээ хийх	Судалгаа үнэлгээний тайлан	Үнэлгээ хийгдэж зөвлөмж хургуулна.	НЭМҮТ, ХАБЭМТ, Улс хувийн их дээд сургуулиуд	МХЕГ, НМХГ	2018-2020
3.1.6	Орчны эрүүл мэндийн төлөв байдлын эмхэтгэл-3 боловсруулах	Орчны эрүүл мэндийн төлөв байдлын эмхэтгэл-3	Орчны эрүүл мэндийн төлөв байдлын эмхэтгэлийг хэвлүүлж, холбогдох байгууллагуудад хургуулсан байна.	ЭМЯ	НЭМҮТ, ШУА, МАУА	2020
3.1.7	Орчны эрүүл мэндийн төгсгөлтийн өмнөх болон дараах сургалтын хөтөлбөрт үнэлгээ хийх	Хөтөлбөрийн үнэлгээ	Орчны эрүүл мэндийн чиглэлээр мэргэжилтэн бэлтгэж буй бүх их, дээд сургуулийн сургалтын хөтөлбөрт хийгдсэн үнэлгээний дүнг холбогдох байгууллагад танилцуулсан байна.	ТББ	НЭМҮТ, ЭМЯ, БСШУСЯ	2018-2020
3.1.8	Эрүүл ахуйч, тархвар судлаачдын Үндэсний IV зөвлөлгөөн зохион байгуулах	Үндэсний IV зөвлөлгөөн	Зөвлөлгөөнөөс гарсан уриалга, зөвлөмжийг холбогдох байгууллагуудад хургуулсан байна.	МЭАТСНХ, ЭМЯ	НЭМҮТ, МХЕГ, АШУУИС-ийн НЭМС, ХӨСҮТ	2019
Үйл ажиллагааны чиглэл 2. Эрүүл мэндийн нөлөөллийн үнэлгээ хийх чадавхийг үндэсний түвшинд бэхжүүлэх						
3.2.1	Эрүүл мэндийн нөлөөллийн	Журам,	Эрүүл мэндийн нөлөөллийн	ЭМЯ	НЭМҮТ	2018-

	үнэлгээ хийх журам, аргачлал боловсруулж, хэрэгжилтэд хяналт тавих	аргачлал	үнэлгээ хийх эрх зүйн орчин бүрдсэн байна.			2019
3.2.2	Эрүүл мэндийн нөлөөллийн үнэлгээ хийх шинжээч, сургагч багш бэлтгэх сургалтын хөтөлбөр боловсруулан шинжээч, үндэсний сургагч багш нарыг бэлтгэх, гарын авлага боловсруулах	Шинжээч бэлтгэх сургалтын хөтөлбөр Бэлтгэгдсэн нөлөөллийн үнэлгээ хийх шинжээч, сургагч багшийн тоо	Эрүүл мэндийн нөлөөллийн үнэлгээ хийх чадавхи бүрдсэн байна.	НЭМҮТ, АШҮҮИС-ийн НЭМС	ЭМЯ, БОАЖЯ	2018-2020
3.2.3	Эрүүл мэндийн нөлөөллийн үнэлгээ хийсэн тайлан, зөвлөмжийг олон нийтийн мэдээллийн хэрэгслээр мэдээлэх	Үнэлгээний дүгнэлт, зөвлөмж	Эрүүл мэндийн нөлөөллийн үнэлгээ хийсэн тайлан, зөвлөмжийг холбогдох байгууллагуудад хүргүүлсэн байна.	ЭМЯ	Үнэлгээний баг	2018-2020
Үйл ажиллагааны чиглэл 3. Орчны эрүүл мэндийн тандалт, судалгааны лабораторийн чадавхийг бэхжүүлэх						
3.3.1	Нийгмийн эрүүл мэндийн үндэсний төвийн лабораторийн биомониторингийн хүчин чадлыг нэмэгдүүлэх, шаардлагатай тоног төхөөрөмж, багаж хэрэгслээр хангах	Орчны эрүүл мэндийн шинжилгээний лаборатори	Орчны эрүүл лабораторийн нэмэгдэж шинжилгээний чанарын үзүүлэлт сайжирсан байна.	ЭМЯ	НЭМҮТ, АНЭМГ	2018-2020
3.3.2	5 аймгийн нийгмийн эрүүл мэндийн төвд тандалт, судалгаа хийх лаборатори шинээр байгуулж шаардлагатай тоног, төхөөрөмжөөр хангах, хүний нөөцийг сургах	Аймгийн НЭМ-ийн төвүүдэд орчны эрүүл мэндийн лаборатори	5 аймгийн орчны эрүүл мэндийн лабораторийн хүний нөөц болон арга зүйн чадавхи нэмэгдэж шинжилгээний чанарын үзүүлэлт сайжирсан байна.	ЭМЯ	НЭМҮТ	2018-2020
Зорилт 4. Уур амьсгалын өөрчлөлтөөс хүний эрүүл мэндэд учирч болох аюул, эрсдэлийн үед хариу арга хэмжээ авах чадавхийг бэхжүүлэх						
Үйл ажиллагааны чиглэл 1. Хүн амын дунд уур амьсгалын өөрчлөлтийн үр дагавар, хүний эрүүл мэндэд үзүүлэх нөлөөллийн талаар мэдлэг, ойлголт бий болгох, хүн амд эрүүл мэндээ хамгаалах дадал, хандлагыг төлөвшүүлэх						

4.1.1	“Уур амьсгалын өөрчлөлтийн үр дагавар, хүний эрүүл мэндэд үзүүлэх нөлөөллийг бууруулах боломж” зөвлөгөөн зохион байгуулж, шийдвэр гаргагч, бодлого боловсруулагч нарыг оролцуулах	Зөвлөгөөнөөс гарсан уриалга, зөвлөмж	Зөвлөгөөнөөс гарсан уриалга, зөвлөмжийг холбогдох байгууллагуудад хүргүүлсэн байна.	БОАЖЯ, Уур амьсгалын өөрчлөлтийн ажлын алба, ЭМЯ	НЭМҮТ, АНЭМГ	2017-2020
4.1.2	Уур амьсгалын өөрчлөлтөөс эрүүл мэндээ хамгаалах дадал, хандлагыг хүн амд төлөвшүүлэх талаар олон нийтэд зориулсан мэдээлэл, гарын авлага боловсруулж түгээх	Сургалт сурталчилгаа, гарын авлага, инфографик	Гарын авлага боловсруулж нийтийн хүртээл болгосон байна.	МАУА, НЭМҮТ, ЗӨСҮТ	ЭМЯ, МАУА, АНЭМГ	2018-2020
4.1.3	Уур амьсгалын өөрчлөлтийн үр дагавар, хүний эрүүл мэндэд үзүүлэх сөрөг нөлөөлөл, түүнд дасан зохицох мэдлэг, арга хэрэгсэл, техник, технологийн талаарх мэдээлэл, сургалт, сурталчилгааг өргөжүүлэх	Сургалт сурталчилгаа, гарын авлага, инфографик	Гарын авлага боловсруулж нийтийн хүртээл болгосон байна.	МАУА, НЭМҮТ, ЗӨСҮТ	ЭМЯ, МАУА, АНЭМГ	2018-2020
Үйл ажиллагааны чиглэл 2. Уур амьсгалын өөрчлөлтийн үр дагавар, хүний эрүүл мэндэд үзүүлэх нөлөөллийг судлах						
4.2.1	Монгол орны газар зүйн байршил болон уур амьсгалын өөрчлөлтийн үр дагавраас хүн амын эрүүл мэндэд үзүүлэх нөлөөллийг судлан тогтоох, олон нийтэд мэдээлэх	Судалгааны тайлан	Судалгааны үр дүнг нийтийн хүртээл болгосон байна	ШУА, МАУА, НЭМҮТ	ХӨСҮТ, ЗӨСҮТ	2018-2020
4.2.2	Уур амьсгалын өөрчлөлтийн үр дагавар, хүн амд үзүүлэх нөлөөллийн талаарх хүн амын мэдлэг, хандлагад судалгаа хийх	Судалгааны тайлан	Судалгааны үр дүнг нийтийн хүртээл болгосон байна	БСШСЯ, МАУА	НЭМҮТ	2019
4.2.3	Анагаахын шинжлэх ухааны судлаач, эрдэм шинжилгээний ажилтнуудыг уур амьсгалын	Чадавхи бэхжүүлэх сургалт	Эрүүл мэндийн чиглэлээр ажилладаг судлаачид, эрдэм шинжилгээний ажилтнуудыг	ШУА, МАУА, НЭМҮТ	ХӨСҮТ, ЗӨСҮТ	2018-2020

	өөрчлөлтийн судалгааны арга зүйн чиглэлээр мэргэшүүлэх		жил бүр чадавхи бэхжүүлэх сургалтад хамруулсан байна.		
4.2.4	Баянхонгор, Говь-Алтай, Завхан аймагт уур амьсгалын өөрчлөлтөөс уудалтэй зоонозын өвчний тархалтыг судлах, хүн амын өртөх эрсдэлийг тогтоох	Судалгааны тайлан	Судалгааны үр дүнг нийтийн хүртээл болгосон байна	ЗӨСҮТ	ЭМЯ 2019-2020

Үйл ажиллагааны чиглэл 3. Уур амьсгалын өөрчлөлтөөс хүний эрүүл мэндэд учирч болох аюул, эрсдэлийг эрт сэрэмжлүүлэх, хариу арга хэмжээ авах чадавхийг бэхжүүлэх

4.3.1	Эрсдэлт бүлгийн хүн амд (хүүхэд, өндөр настан) зориулсан боловсруулах, сургагч багш бэлтгэх сургалт зохион байгуулах	Сургагч багш Сургалт	Сургагч багш бэлтгэх сургалтыг 50-иас доошгүй мэргэжилтэнт хамруулан зохион байгуулж, эмзэг бүлгийн хүн амд хүрсэн байна.	НЭМҮТ	АНЭМГ 2019
4.3.2	Эрүүл мэндийн байгууллагын удирдлага, эмч, НЭМ-ийн мэргэжилтнүүдэд зайн сургалт зохион байгуулах	Сургалтын хөтөлбөр, интерактив сургалтын гарын авлага	Бүх шатлалын эрүүл мэндийн байгууллага чадавхижсан мэргэжилтэнтэй болсон байна.	НЭМҮТ	АНЭМГ, АНЗДТГ 2018-2020
4.3.3	Уур амьсгалын өөрчлөлтийг сааруулах зорилгоор "ЭКО эрүүл мэндийн байгууллага" ааныг аймаг, сум, дүүргийн түвшинд өрнүүлэх	Аянд хамрагдсан байгууллагын тоо	"ЭКО эрүүл мэндийн байгууллага"-ыг сурталчилсан байна.	ЭМЯ	Харьяа байгууллага 2018-2020
4.3.4	Үндэсний чадамжийг бэхжүүлэх хамтарсан сургалт, үзүүлэх сургуулийг жил бүр холбогдох байгууллагуудыг хамруулан зохион байгуулах	Үзүүлэх сургалт зохион байгуулсан байгууллагын тоо	Салбар хоорондын хамтын ажиллагаа, уялдаа сайжирсан байна.	ЭМЯ, НЭМҮТ, ЗӨСҮТ	ОБЕГ, Холбогдох яам, агентлаг, АНЗДТГ 2017-2020
4.3.5	Дамжуулагчаар дамжих эрсдэлийг халдварын	Боловсруулсан сургалт	Дамжуулагчаар дамжих халдварын эрсдэлийг буурсан	ЭМЯ, ЗӨСҮТ, НЭМҮТ	Холбогдох яам, 2017-2020

	бууруулах талаар хүн амд зориулсан мэдээлэл, сургалт, сурталчилгаа зохион байгуулах	сурталчилгааны материал Судалгааны тайлан Сургалтанд оролцогчдын тоо	байна.		агентлаг, Уур амьсгалын өөрчлөлтийн ажлын алба, АНЗДТГ	
4.3.6	Шинэ болон дахин сэргэж буй өвчлөлийг тандах, урьдчилан сэргийлэх гарын авлага боловсруулах	Боловсруулсан гарын авлага	Шинэ болон дахин сэргэж буй өвчлөлийг тандах, урьдчилан сэргийлэх гарын авлагыг холбогдох мэргэжилтнүүдэд хүргүүлсэн байна.	ЗӨСҮТ, ХӨСҮТ	Мэргэжлийн салбар зөвлөл	2019

Зорилт 5. Эрүүл мэндийн байгууллагын хог хаягдлын менежментийг боловсронгуй болгох

Үйл ажиллагааны чиглэл 1. Эрүүл мэндийн байгууллагын хог хаягдлын менежментийн эрх зүйн орчныг боловсронгуй болгох

5.1.1	Эрүүл мэндийн байгууллагын хог хаягдлын менежментийн талаарх журам, зааврыг шинэчлэн боловсруулах, хэрэгжилтэд хяналт тавих	Журам, заавар	Эрх зүйн орчин шинэчлэгдсэн байна.	ЭМЯ, ХӨСҮТ, НЭМҮТ	БОАЖЯ, МХЕГ	2017-2018
		Үнэлгээний тайлан	Үнэлгээ хийгдэж, зөвлөмжийг холбогдох байгууллагуудад хүргүүлсэн байна.	МХЕГ	НМХГ, АНЭМГ	2018-2020
5.1.2	Эмнэлтийн аюултай хог хаягдлыг цуглуулах ут, савны стандартыг шинээр боловсруулж, аюулгүй хайрцагны стандартад нэмэлт, өөрчлөлт оруулах	Батлагдсан стандарт	Хог хаягдлыг цуглуулах ут, савны стандартыг шинээр, аюулгүй хайрцагны стандартыг шинэчлэн боловсруулж батлуулна.	ЭМЯ, ХӨСҮТ	МХЕГ, СХЗГ	2017-2020

Үйл ажиллагааны чиглэл 2. Эрүүл мэндийн байгууллагын хог хаягдлыг хүний эрүүл мэнд, байгаль орчинд ээлтэй болгон боловсруулах байгууламжийн хүчин чадлыг нэмэгдүүлэх

5.2.1	Улаанбаатар хотын эмнэлгийн хог хаягдлын төв байгууламжийг засварлаж, зарим тоног төхөөрөмжийг шинэчлэх	Улаанбаатар хот дахь эмнэлгийн хог хаягдлын төв байгууламжийг шинэчлэн засварлаж, тоног төхөөрөмж шинэчлэгдсэн байна	Эмнэлгийн хог хаягдлыг устгах, боловсруулах байгууламжийн хүчин чадлыг нэмэгдүүлж хэвийн үйл ажиллагааг хангасан байна.	ЭМЯ, БОАЖЯ, СЯ	НЭМГ, НЗДТГ, АНЭМГ	2017-2018
5.2.2	Аймгийн нэгдсэн эмнэлгийн хог хаягдлын байгууламжийг барьж, ашиглалтад оруулж, тоног төхөөрөмжөөр хангах	8 аймгийн нэгдсэн эмнэлгийн хог хаягдлын байгууламжийг барьж, ашиглалтад оруулж, тоног төхөөрөмжөөр хангасан байна.	8 аймгийн нэгдсэн эмнэлгийн хог хаягдлыг байгаль орчинд сөрөг нөлөө багатай аргаар устгах, боловсруулах байгууламжийн хүчин чадлыг нэмэгдүүлж хэвийн үйл ажиллагааг хангасан байна.	ЭМЯ, БОАЖЯ, СЯ	АНЭМГ, АЗДТГ	2017-2018
Үйл ажиллагааны чиглэл 3. Эрүүл мэндийн байгууллагын хог хаягдлын анхан шатны бүртгэл, мэдээллийг сайжруулж, нотолгоонд суурилсан үнэн зөв мэдээллийг шийдвэр гаргахад ашиглах						
5.3.1	Эрүүл мэндийн байгууллагын хог хаягдлын мэдээллийг авах анхан шатны бүртгэл, маягтыг боловсронгуй болгох, мэдээллийн давтамж, урсгалыг тодорхой болгох	Батлагдсан журам	Мэдээний сангийн баяжилт	ХӨСҮТ	АНЭМГ, ЭМБ	2017-2020
5.3.2	Эрүүл мэндийн байгууллагын хог хаягдлын чиглэлээр мэдээ мэдээлэл цуглуулах талаар сургалт зохион байгуулах	Батлагдсан хөтөлбөр, сургалтын тайлан	Сургалтад хамрагдсан эрүүл мэндийн байгууллагын ажилтаны тоо	ЭМЯ, ЭМХТ	Харьяа байгууллагууд	2018-2020
Үйл ажиллагааны чиглэл 4. Эрүүл мэндийн байгууллагын хог хаягдлын менежментийн чиглэлээр хүний нөөцийн чадавхийг дээшлүүлэх						
5.4.1	Эмнэлгийн хог хаягдлын менежментийн талаарх хөтөлбөр	Сургалтын хөтөлбөр	Холбогдох чиглэлээр төгсөлтийн өмнөх болон дараах	ЭМЯ, ЭМХТ, ХӨСҮТ	МХЕГ, НЭМҮТ	2017-2020

	төгсөлтийн өмнөх болон дараах сургалтын хөтөлбөр боловсруулж, хэрэгжүүлэх	Сургалтанд оролцогчдын тоо	сургалтыг зохион байгуулдаг байгууллагын багш, мэргэжилтнүүд сургалтад хамрагдсан байна.			
5.4.2	Эмнэлгийн хог хаягдлын менежментийн талаар эрүүл мэндийн байгууллагын хог хаягдал хариуцсан ажилтан болон эрүүл мэндийн ажилтнуудад ажлын байрны сургалтыг тогтмол зохион байгуулах	Сургалтанд оролцогчдын тоо	Ажлын байрны сургалтын төлөвлөгөөнд эмнэлгийн хог хаягдлын менежментийн сургалтыг тусгаж, сургалт зохион байгуулсан эрүүл мэндийн байгууллагын тоо	ХӨСҮТ	МХЕГ, АНЭМГ Хувийн хэвшлийн эмнэлгүүдийн холбоо, ТББ	2018-2020
5.4.3	Эрүүл мэндийн байгууллагын удирдах ажилтан, эмч, эмнэлгийн мэргэжилтнүүдийг эмнэлгийн хог хаягдлын менежментийн талаарх туршлага судлах сургалтад үе шаттайгаар хамруулах	Сургалтанд оролцогчдын тоо	Эрүүл мэндийн байгууллагын хог хаягдлын менежмент сайжирсан байна.	ХӨСҮТ	МХЕГ, АНЭМГ	2018-2020
5.4.4	Эмнэлгийн хог хаягдлын менежментийн талаарх гарын авлага, сурталчилгааны материалыг хэвлэмэл болон цахим хэлбэрээр олон нийтэд түгээх	Гарын авлага, мэдээлэл сургалт, сурталчилгааны материал, инфографик	Эрүүл мэндийн байгууллагуудад эмнэлгийн хог хаягдлын менежментийн талаарх гарын авлага, сурталчилгааны материалыг хэвлэмэл болон цахим хэлбэрээр хүргүүлсэн байна.	Харьяа байгууллагууд	ЭМЯ	2018-2020
Зорилт 6. Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн нөхцөлийг сайжруулах						
Үйл ажиллагааны чиглэл 1. Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн нөхцөлийг сайжруулах эрх зүйн орчныг боловсронгуй болгох, салбар хоорондын хамтын ажиллагааг өргөжүүлэх						
6.1.1	Эрүүл мэндийн бүх шатны байгууллагад эрхэлж байгаа ажил, үйлчилгээ болон ажлын байранд эрсдэлийн үнэлгээ хийх	Үнэлгээний тайлан зөвлөмж	Үнэлгээний дүнд үндэслэн зөвлөмж гарсан байна.	ЭМЯ, АШУИС-ийн НЭМС	НЭМҮТ, ХАБЭМТ	2018-2020
6.1.2	Ажилтныг эрүүл мэндийн			ЭМЯ	ХНХЯ	2018

	урьдчилсан болон хугацаат үзлэгт хамруулах журмыг шинэчлэн боловсруулах, хэрэгжилтэд хяналт тавих	Батлагдсан журам	Хөдөлмөрийн нөхцлөөс шалтгаалсан өвчлөл буурна.			
6.1.3	Хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, эрүүл ахуйн орчныг сайжруулах төлөвлөгөөг эрүүл мэндийн бүх шатны байгууллагад боловсруулан хэрэгжүүлэх, хэрэгжилтийг 2 жил тутамд үнэлэх	Үнэлгээний тайлан зөвлөмж	Үнэлгээ хийгдэж, зөвлөмж гарсан байна.	ЭМЯ	ЭМБ	2018, 2020
6.1.4	Хөдөлмөрийн эрүүл мэндийн эрх зүйн баримт бичигт үнэлгээ хийх, боловсронгуй болгох	Үнэлгээний тайлан зөвлөмж	Үнэлгээ хийгдэж, зөвлөмж гарсан байна.	ЭМЯ, АШУУИС-ийн НЭМС	МХЕГ, НЭМҮТ, ХАБЭМТ	2019
6.1.5	Эрүүл мэндийн байгууллагын Хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, эрүүл ахуйн орчныг сайжруулах төлөвлөгөө боловсруулж, хэрэгжүүлэх	Батлагдсан төлөвлөгөө хэрэгжилт	Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн орчин сайжирсан байна.	ЭМЯ, АШУУИС, НЭМҮТ, ХАБЭМТ	Бүх шатны эрүүл мэндийн байгууллага	2017-2020
6.1.6	Эрүүл мэндийн анхан шатны тусламж үйлчилгээгээр дамжуулан ажиллагсдад хөдөлмөрийн эрүүл мэндийн суурь тусламж үйлчилгээг хүргэх аргыг практикт нэвтрүүлэх ажлыг турших	Затвар эмнэлгийн тоо	Хөдөлмөрийн эрүүл мэндийн суурь тусламж үйлчилгээг хүргэх аргыг практикт нэвтрүүлэх ажлыг эхлүүлсэн байна.	ЭМЯ, ХЯ, ХАБЭМТ	МХЕГ, НЭМҮТ	2017-2020
Үйл ажиллагааны чиглэл 2. Мэргэжлээс шалтгаалсан өвчний бүртгэл, мэдээллийг боловсронгуй болгох						
6.2.2	Мэргэжлээс шалтгаалсан өвчнийг мэдээлэх анхан шатны бүртгэл мэдээллийг "Эрүүл мэндийн статистикийн мэдээлэл"-д тусгах асуудлыг судлах	Батлагдсан журам	Эрүүл мэндийн статистикийн нэгдсэн бүртгэлд тусгагдаж мэдээлэгдсэн байна.	ЭМЯ, ЭМХТ, ХАБЭМТ	ХНХЯ	2018

Үйл ажиллагааны чиглэл 3. Бичиг уурхай эрхлэгчид болон тэдний гэр бүлийнхний эрүүл мэндийг хамгаалах, дэмжих, мэргэжлээс

Шалтгаалсан өвчинд өртөхөөс урьдчилан сэргийлэх						
6.3.1	Бичил уурхай бүхий аймаг, сумын эмч, эмнэлгийн мэргэжилтнүүдийг мэргэжлээс шалтгаалсан өвчин, осол, гэмтэл, химийн бодисын хордлогыг оношлох, эмчлэх, урьдчилан сэргийлэх чиглэлээр үе шаттайгаар сургалтанд хамруулах	Сургалтын хөтөлбөр эмч, эмнэлгийн ажилтан сургагдсан байна.	Алслагдсан аймгийн сум, өрхийн эмнэлгийн түвшинд бичил уурхай эрхлэгчдийн мэргэжлээс шалтгаалах өвчин, осол, гэмтэл, химийн бодисын хордлогыг оношлох, эмчлэх, урьдчилан сэргийлэх чиглэлээр эмч, эмнэлгийн ажилтны чадавхи бэхжсэн байна.	ЭМЯ	НЭМҮТ, АШУУИС-ийн НЭМС, АМГТТ	2017-2018
6.3.2	Бичил уурхай эрхлэгчдийг явууллын эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ үзүүлж, урьдчилсан болон хугацаат үзлэгт хамруулах	Урьдчилсан болон хугацаат үзлэгт хамрагдсан бичил уурхайчдын тоо	Урьдчилсан болон хугацаат үзлэгт хамрагдсан бичил уурхайчдын тоо	ЭМЯ	НЭМҮТ, АШУУИС-ийн НЭМС, АМГТТ, АНЗДТГ	2017-2018
6.3.3	Бичил уурхай эрхлэгч болон тэдний гэр бүлийнхнийг мэргэжлээс шалтгаалсан өвчин, осол, гэмтэл, химийн бодисын хордлогоос урьдчилан сэргийлэх арга хэмжээнд хамруулах ажлыг зохион байгуулах	Сургалтын хөтөлбөр Сурталчилгааны материал	Бичил уурхайчид болон тэдний гэр бүлийн гишүүд сургалт, сурталчилгаанд хамрагдсан байна.	ЭМЯ	НЭМҮТ, АШУУИС-ийн НЭМС, АМГТТ, АНЗДТГ	2017-2018
Зорилт 7. Хүний эрүүл мэндэд химийн бодисын үзүүлэх нөлөөллийг тандан судлах						
Үйл ажиллагааны чиглэл 1. Хорт хавдар үүсгэгч бодисын хэрэглээг бууруулах, хориглох						
7.1.1	Монгол Улсад ахуйн болон үйлдвэр, үйлчилгээний зориулалтаар хэрэглэж байгаа бараа, бүтээгдэхүүн, химийн бодист хавдар үүсгэгч бодисыг илрүүлэх тандалт, судалгаа хийх, хавдар үүсгэгч бодис бүхий бараа, бүтээгдэхүүн, химийн бодисын хэрэглээг	Жагсаалт Судалгааны тайлан Зөвлөмж	Засгийн газрын тогтоол гарч, хэрэгжсэн байна.	БОАЖЯ, ЭМЯ	НЭМҮТ, АШУУИС-ийн НЭМС, ХАБЭМТ	2017-2020

	бууруулах, хориглох чиглэлээр эрх зүйн орчин бүрдүүлэх				
7.1.2	Аймаг, нийслэлийн нэгдсэн эмнэлэгт хор судлалын чиглэлээр ажиллах эмч нарыг мэргэшүүлэн сургах	Сургалтанд оролцогчдын тоо	Нэгдсэн эмнэлэгт хор судлалын чиглэлээр ажиллах мэргэшсэн эмч нарын тоо жил бүр нэмэгдсэн байна.	ЭМХТ, ЭМЯ	НЭМҮТ 2017-2020
7.1.3	Хор судлалын чиглэлээр үндэсний түвшинд судалгаа, шинжилгээ хийх чадамжийг нэмэгдүүлэх	Тоног төхөөрөмж Сургалтанд оролцогчдын тоо	Химийн хордлого, тохиолдлын үед шинжилгээтэйгээр тандалт хийх чадавхи бүрдсэн байна.	ЭМЯ	НЭМҮТ, МХЕГ 2017-2020
7.1.4	Хор судлалын чиглэлээр үндэсний түвшинд нэгж байгуулах, шинжилгээ хийх лабораториудын хүчин чадалыг нэмэгдүүлэх	Тоног төхөөрөмж	Хор судлалын чиглэлээрх лабораториудын хүчин чадал нэмэгдсэн байна.	ЭМЯ, НЭМҮТ	МХЕГ, АШҮҮИС-ийн НЭМС 2017-2020
7.1.5	Ахуйн хэрэглээний бараа, бүтээгдэхүүн, хүнсний зориулалтын хуванцар савны хэрэглээнд тандалт, судалгаа хийж, хүний эрүүл мэндэд хортой нь тогтоогдсон бараа, бүтээгдэхүүний хэрэглээг хязгаарлах, хориглох чиглэлээр эрх зүйн орчин бүрдүүлэх	Нөлөөллийн арга хэмжээний төлөвлөгөө Сургалт сурталчилгааны материал	Хэвлэл хэрэгслэлээр сэрэмжлүүлэх, ухуулан сурталчлах ажлыг зохион байгуулж, олон нийтийн хүртээл болгосон байна	ЭМЯ, ХХААХҮЯ	НЭМҮТ, ХАБЭМТ, МАУА, АНЗДТГ, ТББ 2017-2020
7.1.6	Монгол улсад хэрэглэж байгаа асбест агуулсан бараа, бүтээгдэхүүний хэрэглээ, түүнээс шалтгаалсан өвчин эмгэгийн тархалтыг судлах, судалгаанаас гарсан зөвлөмжийг хэрэгжүүлэх, урьдчилан сэргийлэх арга хэмжээг нийтэд сурталчлах ажлыг зохион байгуулах	Засгийн тогтоол Сайдын тушаал	Хүнсний зориулалтын бус ахуйн хэрэглээний барааг хэрэглэгч, үйлдвэрлэгч, худалдан борлуулалчийн тоо буурсан байна.	ХХААХҮЯ, ЭМЯ, АШҮҮИС-ийн НЭМС	НЭМҮТ, МХЕГ 2017-2020
7.1.7	Химийн бодисын хордлогын		Химийн бодисын хордлогын	ЭМЯ, МХЕГ	НЭМҮТ, 2017-

	Бүртгэл, мэдээлэл, тандалт хийх журамд нэмэлт, өөрчлөлт оруулах, хэрэгжилтэд хяналт тавих	Батлагдсан журам	Бүртгэл, мэдээлэл, тандалтын журам батлагдаж, хэрэгжүүлсэн байна.		АНЭМГ	2018
7.1.8	Химийн бодисын аюулгүй байдал, тандалт судалгааны нэгдсэн сан бий болгох	Мэдээллийн сангийн журам, дүрэм, заавар	Химийн бодисын аюулгүй байдал, тандалт судалгааны мэдээлэл цуглуулах, нэгтгэх, мэдээлэл солилцох, мэдээний сан бий болгох эрх зүйн орчин бүрдсэн байна.	НЭМҮТ	ХАБЭМТ, НЭМГ, АШҮУИС	2017-2020
7.1.9	Нийтийг хамарсан химийн бодисын хордлогын үед нийгмийн эрүүл мэндийн хариу арга хэмжээг авах, чадавхийг бэхжүүлэх чиглэлээр сургалт зохион байгуулах	Гарын авлага, ном, товхимол Сургалтанд оролцогчдын тоо	Сургалтад хамрагдсан байгууллагын тоо	ЭМЯ	НЭМҮТ, ОБЕГ	2017-2020
7.1.10	Асбесттай холбоотой өвчлөлийг тандах, судлах	Судалгааны тайлан Зөвлөмж	Хэвлэл мэдээллийн хэрэгслээр олон нийтэд хүртээл болгосон байна.	АШҮУИС-ийн НЭМС, МХЕГ, НЭМҮТ	ЭМЯ, Хавдар судлалын үндэсний төв, ХАБЭМТ	2017-2020
7.1.11	Асбестийн хэрэглээг бууруулах, хор хөнөөлийг олон нийтэд сурталчлах ажлыг зохион байгуулах	Сурталчилгааны ажлын тайлан Эрсдэлт бүлэгт зориулсан сургалт, сурталчилгааны материал	Хэвлэл мэдээлэл, нийгмийн сүлжээгээр олон нийтэд хүртээл болгосон байна.	АШҮУИС-ийн НЭМС, МХЕГ, НЭМҮТ	ЭМЯ, БОАЖЯ, ХЯ, Хавдар судлалын үндэсний төв	2017-2020
7.1.12	Хүнсний зориулалтын бус хуванцар савыг ахуйн хэрэглээнд өргөн ашиглаж байгаатай холбогдуулан хүн амын эрүүл мэндэд үзүүлэх нөлөөллийг судлан тогтоох	Судалгаа, тайлан, зөвлөмж	Судалгааны зөвлөмжийг хойбогдох байгууллагад хүргүүлсэн байна.	ЭМЯ, ХХААХҮЯ, БОАЖЯ, ТББ	НЭМҮТ, АШҮУИС-ийн НЭМС, МАУА, ШУА	2018-2020

Үйл ажиллагааны чиглэл 2. Ахуйн шавж, мэрэгч устгал болон ариутгал, халдваргүйтгэлийн ажил, үйлчилгээ эрхэлдэг аж ахуйн нэгж,

байгууллагын чадавхийг нэмэгдүүлэх					
7.2.1	Ахуйн шавж, мэрэгч устгал, ариутгал, халдваргүйтгэлийн чиглэлээр үйл ажиллагаа явуулж байгаа аж ахуйн нэгж, байгууллагын үйл ажиллагаа, ажлын байрын нөхцөл, хүний нөөцөд дэмжлэгт хяналт хийх	Дэмжлэгт хяналт хийх	Аж ахуйн нэгж, байгууллагын үйл ажиллагаа, ажлын байрын нөхцөл сайжирч, хүний нөөцийн чадавхи бэхжинэ.	МХЕГ, ХӨСҮТ	ААН 2018-2020
7.2.2	Ахуйн шавж, мэрэгч устгал, ариутгал, халдваргүйтгэл хийх "ариутгагч" нарыг бага эмч, сувилагч нараас бэлтгэх тогтолцоог бүрдүүлэх, сургалтын хөтөлбөрийг шинэчлэн боловсруулах	Сургалтын хөтөлбөр, Сургалтанд оролцогчдын тоо	Хүний нөөцийн чадавхи бүрдэнэ.	ЭМХТ, ХӨСҮТ, ТББ	ЭМБ 2017-2020
Үйл ажиллагааны чиглэл 3. Ахуйн шавж, мэрэгч устгал болон ариутгал, халдваргүйтгэлийн бодисын хэрэглээ, дасан зохицолд тандалт, судалгаа хийх					
7.3.1	Ахуйн шавж, мэрэгч устгал, ариутгал, халдваргүйтгэлийн бодисын хэрэглээ, дасан зохицлыг судлах, үр дүнг олон нийтэд мэдээлэх	Судалгааны тайлан Зөвлөмж	Судалгааны үр дүнг нийтийн хүртээл болгосон байна	МХЕГ, ХӨСҮТ, ХХААХҮЯ	ЭМЯ, ХАБЭМТ 2017-2020
7.3.2	Ахуйн шавж, мэрэгч устгал, ариутгал, халдваргүйтгэлийн бодисын нэр төрөл, импортлогч байгууллага, тухайн бодисын үйлчлэл, дасан зохицол болон хүний бие махбодид үүсч байгаа гэж нөлөөний талаарх бүртгэл мэдээллийн нэгдсэн сан байгуулах	Сургалтанд оролцогчдын тоо Сургалт сурталчилгааны материал	Хүний бие махбодид үүсч байгаа гэж нөлөөний талаарх бүртгэл мэдээллийн нэгдсэн сан байгуулагдсан байна.	НЭМҮТ, ХХААХҮЯ	АНЗДТГ 2017-2020

Товчилсон үгийн тайлбар (Цагаан толгойн үсгийн дарааллаар)

Яамд

БОАЖЯ - Байгаль орчин, аялал жуулчлалын яам
БХБЯ - Барилга, хот байгуулалтын яам
БСШУСЯ - Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын яам
СЯ - Сангийн яам
УУХУЯ - Уул уурхай, хүнд үйлдвэрийн яам
ХНХЯ – Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам
ХХААХҮЯ - Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам
ЭМЯ - Эрүүл мэндийн яам

Засгийн газрын агентлаг, бусад байгууллага

АНЭМГ – Аймаг, нийслэлийн эрүүл мэндийн газар
АМГТГ - Ашигт малтмал, газрын тосны газар
ААН- Аж ахуйн нэгж
АШУУИС-ийн НЭМС - Анагаахын шинжлэх ухааны үндэсний их сургуулийн Нийгмийн эрүүл мэндийн сургууль
АӨСҮТ-Арьсны өвчин судлалын үндэсний төв
ЗЦА – Замын цагдаагийн алба
СХЗГ –Стандарт хэмжил зүйн газар
НАЧД - Нийслэлийн агаарын чанарын алба
ЗӨСҮТ - Зоноозын өвчин судлалын үндэсний төв
МАУА – Монголын анагаах ухааны академи
МХЕГ - Мэргэжлийн хяналтын ерөнхий газар
МУЗН – Монголын улаан загалмай нийгэмлэг
НМХГ-Нийслэлийн мэргэжлийн хяналтын газар
НЭМГ - Нийслэлийн эрүүл мэндийн газар
НЭМҮТ - Нийгмийн эрүүл мэндийн үндэсний төв

ОБЕГ – Онцгой байдлын ерөнхий газар

ТББ- Төрийн бус байгууллага

УСУГ - Ус сувгийн удирдах газар

ҮСХ - Үндэсний статистикийн хороо

ХАБЭМТ – Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл мэндийн төв

ХӨСҮТ - Халдварт өвчин судлалын үндэсний төв

ЦУОШГ – Цаг уур, орчны шинжилгээний газар

ШУА – Шинжлэх ухааны академи

ЭХЭМУТ- Эх, хүүхдийн эрүүл мэндийн үндэсний төв

ЭМХТ- Эрүүл мэндийн хөгжлийн төв

Орон нутгийн засаг захиргааны байгууллага

АНЗДТГ – Аймаг, нийслэлийн Засаг даргын тамгын газар

АЗДТГ – Аймгийн засаг даргын тамгын газар

НЗДТГ - Нийслэлийн Засаг даргын тамгын газар